

ХЯТАД, МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 60 ЖИЛИЙН СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ АЛСЛАЛТЫН ТҮҮХ БА ГЕОПОЛИТИКИЙН ТАНИН МЭДЭХ ЯВЦ

*Ду Шивэй**

“Таван удаа Монголд очсон нь” (Монголд ажиллаж байсан дипломатчийн 20 жилийн ажлын тэмдэглэл) ба “Найрамдал хамтын ажиллагааны нэгэн жаран” гэсэн 2 номыг уншаад, соёлын алслалтын харьцуулалт хийж судалсан тухайд.

БНХАУ, БНМАУ-ын хооронд (одоогийн Монгол Улс) 1949 оны 10-р сарын 16-ны өдөр хоёр улсын дипломат харилцаа тогтоосноос хойш 61 жил өнгөрөөд байгаа бөгөөд 2009 онд буюу нэгэн жилийн хугацаанд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулсан улс төр, цэрэг, эдийн засаг, соёл урлаг, спорт зэрэг олон талыг хамарсан арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсан нь урьдахыг залгамжлан ирээдүйг нээсэн үйл хэрэг гэмээр.

Түүний дотор Монгол Улсаас Хятадад суугаа ЭСЯ-наас “Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран” гэсэн номыг хэвлэн гаргасан бөгөөд эл ном гэрэл зураг, дурсамжийн хэлбэрээр хоёр орны дипломат харилцаа тогтоосны 60 жилийн харилцаа, хамтын ажиллагааг тусган харуулжээ. Энэ номонд “Монгол Улсын архивын газар, хоёр улсын Гадаад харилцааны яамны архив”¹ болон Синьхуа агентлагийн дээр үеийн гэрэл зургийн архивын материал, түүхэн үйл явдалд оролцогчдын дурсамж, ном хэвлэлд гарсан ховор гэрэл зураг болон бодит эх материалыг өргөн ашиглажээ.

Мөн Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн хорооноос Хятад, Монголын харилцааны хөгжлийн 60 жилийн замналын түүхийг харуулсан Хятадын дипломатч Хуан Жякуйгийн дипломатчийн хорин жилийн ажлын тэмдэглэл “Монголд 5 удаа очсон нь”² гэдэг дурсамж намтар нь өвөрмөц, уншуур сайтай сайн ном болсон байна. Энэ номонд зохиогч хувь хүний туулсан амьдралын туршлагаа өгүүлсэн нь үндэстний хэв маягтай хээрийн судалгаа үнэ цэнээ алддаггүйн нэгээхэн “хэсгийн илрэл” болжээ.

Дээрхи хоёр номд зохиогчид дурсамжийн хэлбэрээр түүхэн байдлыг тэмдэглэн, орчин үеийн геополитик ба хүмүүнлэгийн орчны түүхэн хувьсал дундаас дэлхий дахины ач холбогдолтой дорно дахины өвөрмөц 2 төрлийн соёлын (нүүдлийн малчин ба тариачны суурьшмал) хэв шинжийн шинэчлэлийн явцад соёлын алслалтай солилцооны агуулгыг илэрхийлэн гаргажээ.

Хоёр номын агуулга нь түүхэн үйл явдал болон хүмүүсийн талаар хөндөн бичсэн бөгөөд энэ зохиолд бүгдийг нь тодорхойлон өгүүлэх боломжгүй юм. Харин хоёр ном дахь хувь хүний өөрийн дурсамж болон өөр хүний бусдын талаархи дурсамжийг хоёр талаас нь өгүүлснээрээ, нэгэн

* Ду Шивэй - Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Угсаатны судлал ба хүн судлалын хүрээлэнгийн үндэстний онолын тасгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

төрлийн өвөрмөгц сонирхолтой “соёлын алслалтын харьцуулсан судалгаа” болжээ.

Үүнийг бичигч би бээр Чулууны Далай академичийг нэлээд сайн мэддэг, шавь нь байсны хувьд арван хэдэн жилийн турш уулзаж учирч байсан тул үнэн бодитой сэтгэгдэлтэй болсон. Энэ жил Далай багшийн 80 насны ой тохиож байгаа учраас энэ өгүүлэл нь ихээхэн ач холбогдолтой санагдана. “Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран” номын 127-130-р хуудсанд шинэ монгол үсэг болон хятад хэлээр Далай багшийн дурсамж хэвлэгдсэн. “Монголд таван удаа очсон нь” номын 192-193 дугаар хуудсанд номын зохиогч “Эрдэмтэн дипломатч Чулууны Далай” гэсэн өгүүлэлдээ академич Далайтай харилцаатай байсан хийгээд түүний талаархи үнэлэлтээ тодорхой бичсэн байна.

Одоо энэ 2 өгүүллийн зохиогчийн намтар болон үйл явдлын орчин байдлын талаар харьцуулж, судалгаа хийе:

Академич Далай 1929 онд БНМАУ-ын (одоогийн Монгол Улс) баруун хязгаарын Ховд аймгийн Зэрэг суманд захчин үндэстний малчин айлд төрсөн. Түүний төрсөн нутаг бол Монголын өндөрлөг Алтайн нурууны хамгийн өндөр газар, Монголын нүүдэлчин малчны уламжлалт соёл маш гүн гүнзгий дэлгэрсэн бүс нутаг бөгөөд баруун Монголын нутгийн аялгуу нь зүүн хэсгийн халх нутгийн аялгуунаас нилээд ялгаатай. Академич Далай 1950 онд дунд сургууль төгсөөд Улаанбаатар хотод очиж Монголын хамгийн том сургууль (Чойбалсангийн Их Сургуульд) МУИС-д түүхийн мэргэжлээр сурч, түүний амьдралын хотжилт болон интернациональжих өөрчлөлт эхэлсэн. “1952 онд Бээжин Их Сургуульд суралцсанаар анхны 3 оюутан, ирж байснаа эргэн дурсахад мөн ч сайхан санагдана. Би тэр жилийн байдлыг дурсан санах бүрдээ сэтгэл догдолдог... Бээжинд ирэхэд бид гурвыг мөн ч халуун дотно угтаж авсан даа. Одоо бодоход төрийн зочин шиг л авсан мэт санагдана. Бид ч ирэхдээ Хятадын талаар ихээхэн буруу ойлголттой байснаа мэдэрсэн. Ер нь тэр үед их сайхан байжээ.”³ Үүнээс үзэхэд ноён Далай гуай тэр үед улсынхаа дотоод бүс нутгийн соёлын ялгаатай байдлыг мэдэж, улс хоорондын үндэстний соёл болон улс төрийн ухамсарын тал дээр хоёр удаа гео-танин мэдэхүйн эргэлт гарч, соёлын алслалтыг хүртсэн байна.

Элчин сайд Хуан Жякуй 1943 онд төрсөн, Хятадын өмнөд хязгаарын Гуандун мужийн Наньхай сяний Шанбай гацааны хүн бөгөөд энэ гацаа нь тус мужийн “загас амууны нутаг” гэж алдаршжээ. Түүний өвөг дээдэс дээр үед Фошаньд нүүдэллэн ирж сууж байсан. Фошань нь халуун дулаан бүсэд байрладаг, нэхмэл, шаазан эдлэлээр нэртэй, “Гуандунгийн шаа торгоны төв”, “өмнөд орны шаазангийн нийслэл” гэх зэргээр алдаршсан, хань үндэстний соёлын арвин түүхтэй нутаг юм. “Төрсөн нутгаа ярихад, нутгаа их санадаг. Гуандун хоол, далайн гаралтай бүтээгдэхүүн болон Фошаний өвөрмөгц хүнс, хүйтэн чулуун хавтант зам, наймаачдын үнэ хаялцах дуу бүгд миний тархинд гүн хоногшиж, одоо хүртэл чихэнд сонсогдох мэт санагддаг. 1960 оны 8-р сард Бээжин Их Сургуульд шалгуулж элсээд, 3 өдөр 2 шөнө галт тэргээр түмэн уул мянган голыг алслан явахад төрсөн сэтгэгдэл нь “Хөх мөрнийг

гатласнаас хойш уур амьсгалын ялгаа их байсанаар барахгүй газрын байц, байгалийн үзэмж, хэл яриа болон амьдралын дадал заншил мөн ихээхэн өөрчлөгдөж, өөр нэгэн ертөнцөд очсон мэт байв.”⁴ ... Галт тэрэг хойд зүгийг чиглэн явсаар ээж мөрөн –Шар мөрнийг гаталж Бээжин хүрэхэд миний сэтгэл мөн ч догдож байв. Эх болсон эх орон минь, хүү тань таны зүрх болсон эртний нийслэл Бээжин рүү чиглэж явна”⁵. (Бээжин Их Сургуулийн) Дорно дахины хэл уран зохиолын факультетийг 1946 онд дорно дахины нэрт эрдэмтэн профессор Зи Сяньлинь нар үндэслэн байгуулсан... “Монгол хэлний тусгай мэргэжээр 1949 оноос сургах болж, монголын халх аялгуу болон кирилл монгол үсгийг голлон шинэ монгол хэл заах болсон, “нутгийн нэгэн хүн намайг ятган монгол жижиг улс, хүн ам цөөтэй, монгол хэл сураад ямар ч ирээдүй байхгүй, эртхэн “том хэл” сурвал дээр гэж намайг ятгаж байв. “Сайхан сэтгэлт хүний” ятгалга надад нөлөөлөхгүй байсангүй, нэг хэсэгтээ сэтгэл минь дэглээж байлаа. Яг энэ үед факультетийн удирдлага болон багш нар минь улс төрийн үүднээс бидний тусгай мэргэжлийн талаархи үзэл бодлыг төвлүүн болгоход тусалж хамгийн гол нь сурах зорилтоо тодорхойлж эх орныхоо төлөө суралцах зориг санаа чухал гэдгийг зааж байлаа. Зөвхөн сурах зорилт тодорхой байвал ямар мэргэжил сурах нь хамаагүй, хэдийгээр жижиг улсын хэл байсан ч маш их ирээдүйтэй. Харин ч улс төрийн хувьд чиглэлээ алдвал ямар ч мэргэжил сурсан байсан эх орондоо хувь нэмрээ оруулж чадахгүй... ингээд монгол хэлийг сурах болсон юм.”⁶ Эндээс элчин сайд Хуан Жякуй тухайн үед мөн улсын доторхи бүс нутгийн соёлын ялгааг мэдэж, улс хоорондын үндэстний соёл, улс төрийн чиг ухамсарын тал дээр хоёр удаа гео-танин мэдэхүйн эргэлт хийж, соёлын алслалтыг мэдэрсэнээ номдоо нэн тодорхой, үнэн бодитой дүрслэн бичжээ. Өөр өөр газар нутагтай хоёр өөр үндэстний соёлын орчин байдалд хоёр зохиогч нэгэн өвөрмөц үеийн “хятад маягийн хээрийн амьдралыг” адилхан туулж өнгөрөөжээ.

Элчин сайд Хуан Жякуй тухайн үеийнхээ амьдралыг дүрслэн бичихдээ: “20-р зууны 60-аад оны их сургуулийн оюутан ном үзээд зогсохгүй биеийн хүчний хөдөлмөрт бас оролцох хэрэгтэй байв. Сургуульд ороод удалгүй бид манай факультетийн болон бусад факультетийн оюутнуудтай хамт 13 хааны бунханы усан сангийн барилга дээр ажилласан. Тэр жил онцгой хүйтэн, тэнгэр бүүдгэр, цас ихтэй өвөл байв. Бидний ажил бол жоотуугаар газар ухаж шороог зөөх ажил бөгөөд өдөр бүр тодорхой хэмжээний шороог зөөж дуусгах үүрэгтэй байв. Энэ нь биеийн хүчний зүдэргээтэй хүнд хөдөлмөр бөгөөд үргэлж иддэг гол хоол вотоу эрдэнэ шишийн боов байсан бөгөөд хоолонд мах бараг байхгүй. Би дөнгөж Гуандунгаас Бээжинд ирсэн өмнө газрын хүн, өмнөд нутгийн жихүүнд өмсдөг хөвөнтэй нимгэн хүрэм өмссөн ч тал талаас салхи нэвт үлээнэ. Энэ удаа би тэсгим хүйтэн гэдгийг голдоо ортол мэдэрсэн билээ. Нэгэн оюутан намайг дулаан байлгахын тулд нэгэн сүрлэн олсоор миний нуруугаар уяж өгч байв. Хүйтэн салхи хэсэг үлээхэд би даарсандаа дагжин чичирнэ. Одоо эргэн санахад би тэр үед яаж тэсэж байснаа мэдэхгүй байна. Би уулаасаа вотоу идэж сураагүй ч ажил хийхэд их өлсөж ядарч байсан

болохоор түүнийг идэхэд их л амттай санагддаг байлаа. Ажил хөдөлмөрөө дуусахад турж эцээд харлаж байсан ч бие минь чийрэгжиж тэр үеийн аман ярианд хэлдгээр арьсаа наранд харлуулж, үзэл санаагаа хатуужуулж билээ”⁷ гэж дурсан бичжээ.

Академич Далай Бээжин Их Сургуулийн талаар дүрслэн бичихдээ: “Тэр үед биднийг сурч байхад оюутнууд бүр хөдөө тосгонд очиж сараар ажил хийж тариачдад тусална. Харин гадаад оюутнууд бол саналаараа явна. Би 10 хоног хөдөө явж тариачдын гэрт сууж үзсэн. Тэр үед үнэхээр мартахын аргагүй сонин сэтгэгдэл надад үлдсэн. Тэр үеийн хөдөөгийн тариачид их ядуу, өрөвдөлтэй. Гэхдээ хүн чанартай, байгаагаараа л хүнийг дайлна. Тэд цагаан будаа идэх нь ховор. Голдуу “вотуу” гэдэг хивгээр хийсэн мантуу иднэ. Хоолойгоор ороход ч хэцүү дээ. Гэвч би идэж л байсан. Тэр тариачин айлтайгаа татуулсан зургаа одоо харахад хичнээн сонин дурсгалтай гээч. Ямар ч хэлний байсан энгийн ард түмний найрамдлын нэгэн жишээ энэ буюу. Одоо түүнийгээ гаргаж үзэхэд өнгөрсөн тэр үедээ эргэж очих мэт тухайн үеийн байдал нүдний өмнө харагдах шиг болдог. Зураг болгон нь дурсгалтай миний үнэт ховор зүйл юм. Үнэнийг хэлэхэд хэл яриа нэвтэрч чадах эсэх нь чухал бус миний эдгээр гэрэл зураг бол ердийн олон түмэнтэй найрсаг харилцаж байсны гэрч баримт юм.”⁸ Энэ бол нүүдэлчний соёлын орчин нөхцөлд амьдарч байсан хүн анх удаа тариачны соёлын амьдралыг биеэрээ мэдрсэн сэтгэгдэл юм.

Мөн тариачны соёлын орчинд амьдардаг хүн анх удаа нүүдэлчний соёлыг өөрийн биеэр мэдрэхэд ямар сэтгэгдэлтэй байх вэ? Элчин сайд Хуан Жякуйгийн тэмдэглэлд: “1964 оны зуны эхээр бид “монгол хэлний” 4-р ангид Ни багшийн удирдлаган дор ӨМӨЗО-ны Шилийн Гол аймгийн Шилийн хотын ойролцоо нэгэн малчин айлд дадлага хийсэн. Энэ аймаг монгол улстай маш ойрхон, хэл яриа нь халх аялгуутай ойролцоо... Цэлмэг хөх тэнгэр, хөвөн цагаан үүл, номин ногоон зүлэгтэй тэр нутгийн үзэсгэлэн нь анх удаа их талыг үзсэн бидний сэтгэлд хоногшин үлджээ. Өдөр нь бид гэрийн эзнийг дагаж хонь хариулдаг, шөнө нь гэрийн эзний “ажаа”-гийн хажууд унтдаг байв. Монгол үндэстэн ард түмэн угаасаа зочломтгой зангаараа алдаршсан бөгөөд энэ айл мөн л тийм байлаа. Биднийг дайлах гэж гэрийн эзэн зэрлэг гогодтой хонины махтай сагагийн гурилтай банш хийж өгсөн. Банш идэх нь тэр үед тэдний хувьд, баяр тэмдэглэж байгаа гэсэн үг байв. Хэдэн хоног мах идээгүй, хорхойсож байсан ч хонины мах идэж дасаагүй миний хувьд онцгой амттай байсан. Хүн оршин амьдрахын тулд янз бүрийн орчинд дасан зохицох ёстой. Энэ бол Өвөр Монголын малчин айлд идсэн анхны монгол “тансаг хоол” байлаа... Өндөрлөг нутгийн цаг агаар эх газрын цаг уурт хамаарагдах бөгөөд өглөө оройн дулааны хэм их зөрөөтэй. Нэг орой цахилгаан цахиж аянга нүргэлж, аадар бороо цутгаж, элсэн шуурга нүүр нүдгүй балбав. Бид яаран сандран монгол гэртээ очлоо. Тарчиг малчны гэрийн эсгий туурга бүрээс муудаж навсайсан тул нар, салхи, бороог даахгүй болжээ. Хэрэв бид баян малчин айлд байсан бол “усан хулгана” болтлоо норохгүй байсан. Гэвч бид “ангич байр сууриа”

илэрхийлэхийн тулд “салхи сийгэж бороо дусалсан, нар сар харагдсан гэрт” сууж нийгэмтэй танилцахыг хүссэн... Нэг долоо хоногийн богинохон дадлагын хугацаа дуусав. Бид дадлагаа амжилттай хийж, Шилийн Голын тал нутагт хоргодон хоргосоор хүндэлэм малчин түмнээс салан явсан билээ. Тал нутагт хүрэлцэн очиж дадлага хийж тэндэхийн үзэсгэлэнт байгальтай танилцсан нь маань мартахын аргагүй хоногшин хүний амьдралд ховорхон олдох амьдралын туршлага зузаарсан билээ.⁹

Дээрхи жишээний “хэсгийн илрэлээс” үзэхэд соёлын алслалтын агуулгыг танин мэдэхэд, тухайн хүний энэ соёлын орчинд хүнд хэцүү бэрхшээлийг биеэр туулж танин мэдсэнд оршино. Энэ үеийг судалсан дотоод, гадаадын хүний тухайд гэвэл, биеэрээ танин мэдсэн өөр өөр байр суурь болон өөр өөр мэргэжлийн судалгааны давхаргаас эдгээр асуудлыг задлан шинжилсэн байна.

Эрдэмтэн, дипломатч Далай академич Хятадад 3 удаа урт хугацаагаар сурч, ажиллаж 15 жилийг ардаа орхижээ. 1952-1958 онд Бээжин Их Сургуульд 6 жил эрдэм номд шамдаж, 1962-1968 он, 1986-1989 онуудад академич Далай 2 удаа дипломатчийн хувиар Хятадад ажиллав.¹⁰

1986 онд академич Далай “Монгол, Хятадын харилцаа: 1949-1984”¹¹ сэдвээр докторын зэрэг горилсон зохиолоо бичиж, түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Тус зохиол нь Монгол, Хятад 2 улс дипломат харилцаа тогтоосоны дараа Монгол, Хятадын харилцааг бүх талаар системтэйгээр танилцуулсан Монгол улсын анхны зохиол болсон бөгөөд Монгол, Хятадын харилцааны түүхийн судалгаанд ихээхэн ач холбогдолтой бүтээл болжээ. Завшаан нь: энэ өгүүллийг бичигч миний бие дэд докторын зэрэг горилсон “Өөрчлөлт шинэчлэлийн үеийн Хятад, Монголын харилцаа 1980-1995”¹² зохиолоо академич Далайн удирдлагаар бичсэн юм. Хятад судлаач монгол эрдэмтэн тэрбээр энэ үеийн байдлыг дурсамждаа дүрслэн бичихдээ: “Тэр үед манай сургуульд Лю Шаоци, Жоу Энълай нарын хятадын нам төрийн удирдах хүмүүс ирж уулзалт хийдэг байв. Тэд Хятад улсыг ирээдүйд мэдлэг оюунаар хөгжүүлнэ. Манай улсын хөгжил нэг хэсэгтээ дээшээ ч явна, доошоо ч явна. Муруй тахир замаар замнана. Өлсгөлөнд ч хүрч мэднэ. Тэр бүхнийг тэвчээртэй даван туулж байж хөгжилтэй социализмд хүрнэ. Тэр хөгжилтэй хятад улсыг та нар үзнэ, жолоог нь барилцана” гэх мэтээр ярьдаг байв. Одоо бодоход их л алсыг хардаг ухаантай удирдагчид байжээ гэж бодном.”¹³ Хоёр улс, хоёр өөр төрлийн соёлыг давж өнгөрүүлсэн орчин үеийн шинэтгэл өөрчлөлтийн явц дахь академич Далай гуайн үгнээс түүний туулсан амьдрал, ойлгосон ойлголт улам гүнзгий мэдрэгдэнэ. Академич Далайтай нэгэн үед хамт сурч ажил төрлийн холбоотой байсан элчин сайд Хуан Жякуй түүний талаар үнэлэн тэмдэглэхдээ: “20-р зууны 60-аад онд миний бие Бээжин Их Сургуульд монгол хэлний мэргэжлээр суралцаж байх үед Далай Бээжин Их сургуулийн түүхийн факультетад суралцаж байсан, надаас 2 ангийн дээр байсан, би тэр үеэс л түүнийг таньдаг байсан боловч цөөхөн уулзаж байв. Өнгөрсөн зууны 80-аад онд Далай дахин Монголоос

Хятадад суугаа ЭСЯ-нд дахин томилогдож ажиллахаар ирэхэд нь би ГЯЯ-ны Азийн хэлтэст ажиллаж, түүнтэй олонтаа уулзаж байв. Далай гуай хүнтэй илэн далангүй, ил тод ярилцдаг. Бид хоёр улсын харилцаа, түүхийн асуудлаас эхлээд соёлын солилцоо харилцаа зэрэг асуудлаар чөлөөтэй санал бодлоо солилцдог байв. Тэрээр түүхийн асуудлаархи 2 улсын эрдэмтэд өөр өөр үзэл бодолтой байлаа ч харилцаа солилцоог бэхжүүлж байх ёстой, энэ нь бидний хоорондын найрамдалд нөлөөлөхгүй гэдгээ тодорхой илэрхийлж байсан билээ.

Бид түүнийг албан үүргээ дуусгаад нутаг буцахад нь үдэж халуун дотно яриа өрнүүлж, Улаанбаатарт дахин уулзахын ерөөл талбисанаа тодхон санаж байна. Шуудхан хэлэхэд, Далай бол түүхч хүн, түүний түүхийг үзэх үзэл баримтлал манай улсын эрдэмтэдтэй зөрөлдөөнтэй байдаг. Гэвч бид, 2 улсын харилцаа болон олон улсын байдал зэрэг чухал томоохон асуудал дээр нэгдмэл ойлголт цөөнгүй байсан ба санал нийлэх зүйлээ эрж, зөрүүтэйгээ орхиж байсан гэж хэлж болно.

Түүнтэй харилцаж байхад судалгааны үзэл бодол өөр байх нь бидний нөхөрлөлд нөлөөлж байгаагүй. Далай бол хятад монгол 2 улсын соёлын харилцаанд ихээхэн чармайлт гаргаж, хувь нэмэр оруулсан хүн. Тэрээр манай Элчин Сайдын Яаманд болон надад ихээхэн тусалж байсан. Би нэгэн эрдэмтэн диглопатчтай найз нөхөр байсандаа нэн баяртай байдаг.”¹⁴

Элчин сайд Хуан Жякуй монгол үндэстэн болон монголын соёлын талаар гүн мэдлэгтэй бөгөөд 40 орчим жил зүтгэсэн Хятад, Монголын соёлын харилцааг хөгжүүлэх үйлсэд амжилт гаргасан тул Монгол Улсын ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэнгээс түүнд хүндэт доктор цолыг 2001 оны 11-р сард хүртээсэн билээ.

Дээр дурдсан хоёр “хятад маягийн хээрийн амьдралын” “хэсгийн илрэл”-ийн “сонгодог жишээн”-ээс бид: соёлын харилцаанаас (шууд, дам) - соёлын танин мэдэхүй болон сурах, (сэрлийн ба оюун ухааны) соёлын харьцуулалт ба харилцан ойлголцол соёлын алслалтын солилцоог хүртэл (нийгмийн чанартай) нэгэн төрлийн шинэ соёлын нийтлэг ойлголт бүрэлдэн тогтох гол судсыг харж болно. Тэгвэл энэ өгүүлэлд гарсан хүн бүрийн амьдралын бүхий л учрал нь тухайн хүний хувь тавилан болон түүх бөгөөд үндэстний хувь заяа болон түүхийн нэгэн хэсэг юм. Их түүх нь иймэрхүү мянга түмэн бичигдээгүй болон бичигдсэн бяцхан түүхээс (“хувь хүний намтар, соёлын залгамжлал болон үйл ажиллагааны үзэл санаа”) бүрэлдэн бий болно. Хятад, Монголын харилцааны 61 жилийн хөгжлийн түүхээс тухайн улс, үндэстний соёлын ялгаа буюу соёлын маргаантай үзэгдэл, ёс заншил, зан дадал зэргийг бүрэн зөв танин мэдэх, харьцуулах шаардлагатайн дээр энэ үндсэн дээр тэдний соёлыг хүлээн авч дасан зохицох хэрэгтэй. Түүгээр зогсохгүй соёлын алслалтай солилцооны агуулга болон хүрээ өнөөдөр өргөжсөөр “ардын дипломат бодлого” аажмаар эдийн засаг, нийгмийн хөгжил болон улс төрийн харилцааны давхаргад нэвтэрч, эдийн засгийн даяаршсан хөгжлийг дагалдан улам бүр олны анхаарал татаж байна.

Үүний зэрэгцээ дорнын нүүдлийн малчны соёл, тариачны соёл бол дэлхий дээр маш удаан хугацаагаар оршиж байсан бөгөөд хамгийн их амьдрах чадвартай хоёр төрлийн соёл юм. Тэдний үүсэл нь хоорондоо адилгүй, өвөрмөц өөр өөр онцлог ялгаатай, харилцан бие биенээ нөхвөрлөх чанартай. Энэ 2 төрлийн соёл тэнцвэртэйгээр урагшлан хөгжиж харилцан холдож, дахин нийлж салан ихээхэн урт үйл явцыг тууллаа. Эцэст нь бодитой харилцан бие биенээ дэмжихэд олон эрдэмтдийн хүчин чармайлт хэрэгтэй юм. Иймэрхүү чармайлтын үзэл санаа ба аргын хувьд үүнийг бичигч би бээр Лян Юнжягийн “Андаман арлынхан” номын орчуулагчийн оршил дахь нэгэн мөрийг зээлэн төгсгөлийн үг болгон: “Ямар ч судлаач “бодитой”, “бүрэн төгс”, “зөвөөр” нэгэн үндэстэн угсаатныг танин мэдэх аргагүй гэдгийг хүмүүс аль эрт мэдэж байсан. Тэгвэл хээрийн ажлын субъектив шинжийг хүлээн зөвшөөрөхдөө, хээрийн ажлын амжилтыг хэрхэн тогтоох вэ?.

Нэгэн чухал гарц бол “дахин судлах” явдал байж магадгүй. Амжилттай судалгааг, зөвхөн дахин давтан судалж байж сая “сонгодог жишээ” болгох боломжтой. Дахин судлахад урдах хүний хээрийн судалгааны үнэн эсэхийг тухайлан шалгах бус, харин энэ нийгмийн бусад талын илрэлийг тусгайлан анхаарвал, ихээхэн хэмжээгээр тус нийгмийн хүн судлаач эрдэмтдийн тархийг ажиллуулах боломжтой болно. Иймэрхүү судалгаа нь хэдэн үеийнхний хамтын чармайлтаар сая амжилтад хүрч чадна.”¹⁵ Харин Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын Яамаас эрхлэн хэвлүүлсэн Монгол, Хятадын харилцааны 60 жилийн хөгжлийн замналыг тусган харуулсан “Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран” ном болон Хятадын Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хорооноос хэвлэж гаргасан элчин сайд Хуан Жякуйгийн өөрийн дурсамж тэмдэглэл болох “Монголд 5 удаа очсон нь” (Монголд ажиллаж байсан дипломатчийн 20 жилийн ажлын тэмдэглэл)-д маш олон эх материал болон нарийн учрыг тэмдэглэсэн зүйл нь хожмын хүмүүсийн судалгааны материал болох юм.

Монгол, Хятадын соёлын харилцаа алслан харилцан нэвтрэлцэх нь их үйлсийн хошуучлагч Чулууны Далай багшийнхаа мэндэлсэний 80 жилийн ойг дурсан, өчүүхэн шавь нь энэхүү өгүүллээ зориулав.

ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. Галсангийн Батсүх (ерөнхий редактор) “Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран” Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны хэвлэл, Бээжин хотын Зинзинь Өнгөт Хэвлэлийн ХХК 2009 оны 9-р сар, 5-р тал
2. Хуан Жякуй: “Монголд 5 удаа очсон нь” (Монголд ажиллаж байсан дипломатчийн 20 жилийн ажлын тэмдэглэл) Өвөр Монголын Их Сургуулийн Хэвлэлийн Хороо, 2008 оны 11-р сар, 1-р тал
3. Г.Батсүх, “Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран” 129-р тал “Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич, доктор, профессор Ч.Далайн дурсамж тэмдэглэл”
4. Хуан Жякуй дурьдсан зохиол, 6-р тал
5. Хуан Жякуй дурьдсан зохиол 15-р тал
6. Хуан Жякуй дурьдсан зохиол 16-р тал
7. Хуан Жякуй дурьдсан зохиол 17-р тал
8. Г.Батсүх дурьдсан зохиол 129-р тал
9. Хуан Жякуй дурьдсан зохиол 19-20-р тал
10. Лю Динань, Ц.Ганбаатар “Монгол Хятадын соёлын харилцааны элч академич Ч.Далай” Бээжин Их Сургуулийн Гадаад Хэлний дээд сургуулийн Монгол Судлалын Төв өгүүмж, 2010 оны 10-р сар, 6-р тал
11. Ч.Далай, И.Шима: “Монгол, Хятадын харилцаа: 1949-1984”, орос хэлээр Прага~ 1986 он
12. Ду Шивэй: “Монгол, Хятадын харилцаа: 1980-1995” Монгол Улсын ШУА 1997 он
13. Г.Батсүх дурьдсан зохиол 129-р тал
14. Хуан Жякуй дурьдсан зохиол 192-193-р тал
15. “The Andaman Islanders” by A.R.Radcliffe-Brown “Андаман арлынхан” орчуулсан Лян Ао, хянасан Лян Юнжя, Гуансигийн Багшийн Дээд Сургуулийн Хэвлэлийн Хороо, 2005 оны 12-р сар; орчуулагчийн оршил, 5-р тал

Хятад хэлнээс орчуулсан Г.Булган, Х.Цэгмэд, Л.Бэгзжав